

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг
дэвсгэрт хэрэгжүүлж буй “Жи Эф Ай” ХХК-ний “Химийн бодис
импортолох, хадгалах, худалдаалах” төслийн 2025 оны Байгаль
орчны менежментийн төлөвлөгөө

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр	3
1.2. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байршил	3
1.3. Төслийн хүчин чадал	3
1.4. Химийн бодисын агуулах	4
1.5. Төслийн дэд бүтэцийн байдал	4
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
2.1. Төсөл хэрэгжиж буй газрын өнөөгийн байдал	6
2.2. Төсөл хэрэгжих орчны уур амьсгал	6
2.3. Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч, түүний онцлог	7
2.4. Төсөл хэрэгжих орчны газрын гадарга, хэвлийн тогтоц онцлог	8
2.5. Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг	9
2.6. Төсөл хэрэгжих орчны гадаргын усны судалгаа	9
2.7. Газрын доорх ус буюу гидрогеологийн нөхцөл	10
2.8. Төсөл хэрэгжиж орчны амьтны аймаг, бүрэлдэхүүн	11
2.9. Төсөл хэрэгжих орчны нийгэм, эдийн засгийн хөгжил	12
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	13
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	16
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
4.2. Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө	20
4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	20
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	20
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	20
4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний арга хэмжээний зардал	22
4.8. Бомт-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	23
4.9. Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх хуваарь	23
4.10. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ	24
4.1. Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	24
Хавсралт материалууд	24

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр: “Химийн бодис импортлох, хадгалах, худалдаалах” төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Жи Эф Ай” ХХК, Регистр: 5338735, Улсын бүртгэлийн дугаар 9011205097, Хаяг: Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, 32-р хороо, “Номин гал” ХХКомпанийн түрээсийн байр, Утас: 70113376

1.3. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байршил:

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт “Номин гал” ХХК-н түрээсийн байр, Баруун аймаг явах замд байрлана. Төсөл хэрэгжих газрын координатыг хүснэгт 1-д, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болох Сонгинохайрхан дүүргийн байрзүйн зураг мөн агуулахын байрны байршил, ерөнхий харагдах байдлыг зураг 1,2-д харуулав.

Хүснэгт 1. Газрын булангийн цэгүүдийн солбицол

Дугаар	Солбицол		Цэгүүд	Урт
	Х	Ү		
1	622724.08	5305483.99	1-2	129.82
2	622636.09	5305579.25	2-3	140.93
3	622741.08	5305673.35	3-4	141.23
4	622824.08	5305559.27	4-1	125.06



Зураг 1. Төсөл хэрэгжих газрын байршлын зураг

1.4. Төслийн хүчин чадал

Төслийн хүрээнд ундны, үйлдвэрлэлийн, бассейны болон хаягдал усыг боловсруулан цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн системд шаардлагатай химийн бодис болон бусад ариутгал цэвэрлэгээний зориулалттай 82 төрлийн химийн бодисуудыг ХБНГУ-ын KIC KRONES компаниас оруулж ирдэг бөгөөд 1 жилд нийт 497.6 тн хүртэлх бодисуудыг импортлох, хадгалах, худалдаалахаар төлөвлөсөн байна. Тус бодисуудыг нэр төрөл, зориулалтаар ангилж үзэхэд:

“Жи Эф Ай” ХХК

1. Бассейны усанд хэрэглэгдэх бодисын 6 нэр төрлийн
2. Ундны системд хэрэглэгдэх ариутгалын бодис-1 нэр төрлийн
3. Бактергүйжүүлэлт, цэвэрлэгээний бодис-75 нэр төрлийн бодисууд байна.

Тус химийн бодисуудыг хадгалах агуулах нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт байрлах бөгөөд нэг удаад 100 тн химийн бодис агуулах хүчин чадалтай.

1.4.1. 2025 онд импортоор оруулж ирж борлуулах хэмжээ


2025 онд импортоор оруулж ирэхээр төлөвлөж байгаа хэмжээ нь: **68,3 тонн** байхаар байна.

1.4.2. Аюултай хог хаягдлын гарах хэмжээ

2025 онд зайлуулах аюултай хог хаягдал буюу химийн бодисын хоосон савыг “Цэцүүх трейд” ХХК-тай хийсэн “Аюултай хог хаягдал шилжүүлэх” гэрээний дагуу 2025 онд **0,6 тонн** хог хаягдлыг шилжүүлэхээр төлөвлөсөн.

1.4.3. Бүтээгдэхүүний танилцуулга

Тус төслийн хүрээнд импортоор оруулж ирэх 82 нэр төрлийн химийн бодисуудын зориулалт нь усыг боловсруулан цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн системд шаардлагатай химийн бодис болон хүнсний үйлдвэрлэлд хэрэглэгдэж болох тос тосолгооны материал, ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийхэд тохиромжтой бодисууд байдаг.



Зураг 2. KIC KRONES компанийн бүтээгдэхүүнүүд

Тус бүтээгдэхүүнүүдийн тус бүрийн зориулалт, сав дугаар, савлагаа зэргийг доор хүснэгтэд оруулав.

Хүснэгт 2. Химийн бодисуудын нэр төрөл, савлагаа, хэмжээ

№	Нэршил	CAS №	Химийн томьёо	Савлагаа, хэмжээ, тн
БАССЕЙН УСАНД ХЭРЭГЛЭГДЭХ БОДИС				
1.	Chemochlor T-Granulat	51580-86-0;	нийлмэл бодис	3.33
2.	Chemochlor T-Tablets	87-90-1;	нийлмэл бодис	0.67
3.	Flockfix Granulat	16828-12-9;	нийлмэл бодис	2.33
4.	pH plus Granulat	497-19-8;	нийлмэл бодис	2.67
5.	pH minus Granulat	7681-38-1;	нийлмэл бодис	6.67
6.	Chemochlor Liquid	51580-86-0;	нийлмэл бодис	50.00
УНДНЫ УСНЫ СИСТЕМД ХЭРЭГЛЭХДЭХ АРИУТГАЛЫН БОДИС				
1	Potassium permanganate	7722-64-7;	KMnO ₄	1.00
БАКТЕРГҮЙЖҮҮЛЭЛТ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОДИС				

“Жи Эф Ай” ХХК

1.	KRONES colclean AD 1002	64-02-8; 29132-58-9; 7789-20-0;	нийлмэл бодис	5.67
2.	KRONES colclean AD 1003	29132-58-9; 7789-20-0;	нийлмэл бодис	0.67
3.	KRONES colclean AD 1004	2809-21-4;	нийлмэл бодис	1.00
4.	KRONES colclean AD 1005	120313-48-6;	нийлмэл бодис	3.33
5.	KRONES colclean AD 1009	34590-94-8;	нийлмэл бодис	1.00
6.	KRONES colclean AD 2001	120313-48-6	нийлмэл бодис	6.67
7.	KRONES colclean AD 2002		нийлмэл бодис	2.67
8.	KRONES colclean AD 2003	7789-20-0	нийлмэл бодис	1.00
9.	KRONES colclean AD 2006	34590-94-8;	нийлмэл бодис	4.00
10.	KRONES colclean AD 2007	120313-48-6; 112-34-5; 68439-51-0;	нийлмэл бодис	5.00
11.	KRONES colclean AD 3001		нийлмэл бодис	3.33
12.	KRONES colclean AD 3002	37971-36-1; 7789-20-0;	нийлмэл бодис	6.67
13.	KRONES colclean AD 3003	7664-93-9; 37971-36-1; 7789-20-0;	нийлмэл бодис	6.67
14.	KRONES colclean AD 3004	7664-93-9; 7789-20-0;	нийлмэл бодис	3.33
15.	KRONES colclean C 1201	8028-48-6;	нийлмэл бодис	2.33
16.	KRONES colclean C 1209	107-98-2; 5889-27-5; 124-38-9;	нийлмэл бодис	2.33
17.	KRONES colclean CG 1001		нийлмэл бодис	1.00
18.	KRONES colclean CG 1005	90640-46-3; 67-63-0; 7789-20-0;	нийлмэл бодис	106.67
19.	KRONES colclean CG 4001	112-80-1; 68188-18-1; 111-42-2;	нийлмэл бодис	5.67
20.	KRONES colclean CG 4005	112-80-1; 112-34-5; 55965-84-9;	нийлмэл бодис	16.67
21.	KRONES colclean CG 4007	55965-84-9	нийлмэл бодис	5.67
	KRONES colclean CG 4014	55965-84-9		5.67
22.	KRONES colclean DI 1011	64-19-7; 7722-84-1; 79-21-0;	нийлмэл бодис	5.00
23.	KRONES colclean DI 3001	76-81-52-9; 1310-73-2; 497-19-8;	нийлмэл бодис	8.33
24.	KRONES colclean DI 4001	64-17-5; 71-23-8; 7789-20-0;	нийлмэл бодис	5.67
25.	KRONES colclean DI 6001	55965-84-9	нийлмэл бодис	3.33
26.	KRONES colclean DI 8001	7647-01-0; 7789-20-0;	нийлмэл бодис	4.00
27.	KRONES colclean DI 8002	7758-19-2; 7775-09-9; 1310-73-2; 7789-20-0;	нийлмэл бодис	4.00
28.	KRONES colclean DI 8004	37971-36-1	нийлмэл бодис	2.33
	KRONES colclean DI 8005	7775-09-9	нийлмэл бодис	2.33
29.	KRONES colclean DI 7001	27083-27-8; 7789-20-0	нийлмэл бодис	2.67
30.	KRONES colclean DI 8003	7697-37-2	нийлмэл бодис	2.33
31.	KRONES colclean EV 60	64742-48-9;	нийлмэл бодис	3.33
32.	KRONES colclean FC 1001	68891-38-3	нийлмэл бодис	3.33
33.	KRONES colclean FC 2001	7681-52-9; 1310-73-2; 1643-20-5;	нийлмэл бодис	11.00
34.	KRONES colclean FC 3001	7664-38-2; 69011-36-5; 1643-20-5; 7789-20-0;	нийлмэл бодис	3.33
35.	KRONES colclean FC 4001	64-19-7; 7722-84-1; 69011-36-5; 1643-20-5;	нийлмэл бодис	4.00
36.	KRONES colclean FC 5001	5329-14-6; 61789-40-0; 1643-20-5; 7789-20-0;	нийлмэл бодис	5.67
37.	KRONES colclean FC 1004	22042-96-2;	нийлмэл бодис	2.67
38.	KRONES colclean FC 1005	1310-73-2; 1310-58-3;	нийлмэл бодис	5.00
39.	KRONES colclean Hotclean	8042-47-5;	нийлмэл бодис	1.00
40.	KRONES colclean IC 1002	1310-73-2; 37971-36-1; 7789-20-0;	нийлмэл бодис	16.67
41.	KRONES colclean IC 1003	1310-73-2; 7789-20-0;	нийлмэл бодис	15.00
42.	KRONES colclean IC 1004	7789-20-0;	нийлмэл бодис	4.33
43.	KRONES colclean IC 1005	7789-20-0;	нийлмэл бодис	4.33

“Жи Эф Ай” ХХК

44.	KRONES colclean IC 2001	7681-52-9; 1310-73-2; 7789-20-0;	нийлмэл бодис	15.00
45.	KRONES colclean IC 2002		нийлмэл бодис	4.33
46.	KRONES colclean IC 3001	7697-37-2; 7789-20-0;	нийлмэл бодис	15.00
47.	KRONES colclean IC 3002	7664-38-2; 7697-37-2; 7789-20-0;	нийлмэл бодис	16.67
48.	KRONES colclean IC 4001	7664-38-2; 68188-18-1; 6419-19-8; 7789-20-0;	нийлмэл бодис	5.67
49.	KRONES colclean IC 4002	7664-38-2; 64-18-6; 7789-20-0;	нийлмэл бодис	5.00
50.	KRONES colclean IC 4005	7664-38-2	нийлмэл бодис	5.67
51.	KRONES colclean IC 4006	7664-38-2	нийлмэл бодис	5.67
52.	KRONES colclean MC 1001	1310-73-2; 68188-18-1; 69011-36-5; 8028-48-6; 1643-20-5; 7789-20-0;	нийлмэл бодис	0.67
53.	KRONES colclean MC 1002	68188-18-1; 85117-49-3; 7789-20-0;	нийлмэл бодис	0.67
54.	KRONES colclean MC 1003	5329-14-6; 69011-36-5; 7789-20-0;	нийлмэл бодис	0.67
55.	KRONES colclean MC 1005	5064-31-3; 24938-91-8; 112-34-5;	нийлмэл бодис	2.67
56.	KRONES WET 1	863679-20-3; 7789-20-0;	нийлмэл бодис	3.33
57.	DUROX LRA	7722-84-1	нийлмэл бодис	1.67
58.	Quartasept Plus	7173-51-5; 67-63-0;	нийлмэл бодис	5 л
59.	KRONES colclean Wax	64742-51-4	нийлмэл бодис	3.33
60.	KRONES hydrocare 100	7789-20-0;	нийлмэл бодис	3.33
61.	KRONES hydrocare 300	7789-20-0;	нийлмэл бодис	2.33
62.	KRONES hydrocare 450	-	нийлмэл бодис	2.33
63.	KRONES hydrocare 500	7789-20-0;	нийлмэл бодис	2.33
64.	KRONES hydrocare 1902	1310-73-2; 37971-36-1; 7789-20-0;	нийлмэл бодис	3.33
65.	KRONES hydrocare 2902	7722-84-1; 7789-20-0;	нийлмэл бодис	4.33
66.	KRONES hydrocare 3901	7697-37-2; 7789-20-0;	нийлмэл бодис	4.33
67.	KRONES hydrocare 3902	7697-37-2; 7664-38-2; 7789-20-0;	нийлмэл бодис	2.33
68.	KRONES hydrocare RO 1000	1310-73-2;	нийлмэл бодис	1.00
69.	KRONES hydrocare RO 2000	7664-93-9;	нийлмэл бодис	0.33
70.	A.A. GRADE D (Desiccant)	1344-28-1;	нийлмэл бодис	0.30
71.	Bromine tablets	32718-18-6;	нийлмэл бодис	0.03
72.	Desiccant Capsule (PKT SORB-IT) Silica (Silicon dioxide)	32718-18-6	нийлмэл бодис	0.03
73.	Cleaner for PVC-U pipe and fittings	67-64-1; 78-93-3;	нийлмэл бодис	0.20



Зураг 3. Бассейны усанд хэрэглэгдэх бодисууд



Зураг 4. Бактергүйжүүлэлт, цэвэрлэгээний бодисууд

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Улаанбаатар хот түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн дэнжийн хэсэгт байрладаг. Газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг бөгөөд 1950-2268 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсаар хүрээлэгдэнэ. Богдхан уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн 40 орчим км үргэлжилсэн нуруу юм. Хамгийн өндөр оргил нь далайн түвшинээс дээш 2268 м өндөрт орших Цэцээ гүн юм.



Зураг 31. Төслийн талбайн байр зүйн зураг

Төслийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт үйлчилгээний зориулалттай “Номин гал” ХХКомпанийн түрээсийн байр, Баруун аймаг явах замд байрлана. Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1562-1266 метрийн өндөрт, газрын гадаргын налуу буюу хэвгий 2^0 (градус) байна. Тус химийн бодис хадгалах агуулахын орчин нь хүний болон техникийн үйл ажиллагааны улмаас тодорхой хэмжээгээр газрын гадаргын элэгдэл, эвдрэлд орсон байна.



Зураг 31. Төсөл хэрэгжих газрын өнөөгийн байдал

2.2. Төсөл хэрэгжих орчны хөрсөн бүрхэвч, түүний хэв шинжийн судалгаа

Төсөл хэрэгжиж буй газар нь далайн түвшинээс дээш 1562 метр өргөгдсөн, химийн бодисын агуулахын ойр орчим томоохон үйлдвэржилт байхгүй. Төслийн талбайн орчмын хөрсний ерөнхий байдал нь хүчтэй элэгдэл, эвдрэлд ороогүй, хөрсний бүтэц хэв шинжийн хувьд антропоген болон техноген хүчин зүйлийн нөлөөгөөр эрс өөрчлөлт ороогүй боловч агуулахын орчны газрын хөрс, зам талбайг тохижуулж зүлэгжүүлээгүйгээс хүн, автомашины хөдөлгөөнд өртөн элэгдэлд орох, ил задгай хог хаягдлын цэг байгуулах болон түүнийг ариутгахгүй удах, хогийг зохих график хуваарийн дагуу ачихгүй байх, химийн бодис, материалыг тээвэрлэн зөөх, ачих, буулгах үедээ санамсаргүй алдаж асгах зэрэг шалтгаанаас хөрс бохирдох сөрөг нөлөөлөл гарах магадлалтай байна.

2.3. Төсөл хэрэгжих орчин дахь ургамлан нөмрөгийн өнөөгийн байдал

Ургамлан нөмрөгийн өнөөгийн төрх байдлын хувьд унаган төрхөөрөө, биологийн бохирдол байхгүй байна. Төслийн талбайд үетэн- алаг өвст бүлгэмдэл зонхилж байна.

Үетэн-алаг өвст бүлгэмдэл: Тус бүлгэмдэлд 13 овгийн 23 төрлийн 23 зүйл ургамал бүртгэгдсэн (Хавсралт 2). Үетэнээс *Leymus chinensis* (Trin.) Keng., *Stipa krylovii* Roshev, *Stipa baicalensis* алаг өвснөөс *Artemisia frigida* Willd. 1803, *Artemisia scoparia*, *Heteropappus altaicus* (Willd.), *Amblynotus rupestris* (Pall) M. Pop. ex Serg., *Dontostemon integrifolius* (L.) C.A. Mey, *Chenopodium album* L. 17, *Medicago ruthenica* (L.) Ldb. *Schizonepeta multifida*" ургамлууд тохиолдоно. *Allium polyrhizum* Turcz. ex Regel., *Taraxacum officinale* Wigg., *Arctogeron gramineum* (L.) DC., *Cleistogenes squarossa* (Trin.) Keng., *Potentilla anserina* L., зэрэг ургамлууд ховор тааралддаг. *Astragalus galactites* Pall., *Oxytropis ampullata* (Pall) Pers., *Potentilla gelida* C.A. Mey., *Silene repens* Patr. зэрэг ургамлууд ганц нэг тааралдсан. Насны хэлбэрээр нь авч үзвэл 2 зүйл мод, 1 зүйл сөөг 20 зүйл хэлбэрээр нь авч үзвэл 2 зүйл мод, 1 зүйл сөөг 20 зүйл олон наст ургамал байна.



Зураг 2. Төслийн талбай орчмын ургамал

2.4. Төсөл хэрэгжих орчны ус зүй

Төслийн ойр орчимд томоохон голуудаас Туул гол байдаг ба энд мөн бусад газрын нэгэн адил сүүлийн жилүүдэд тохиолдож буй уур амьсгалын өөрчлөлт, дулаарал, хүний үйл ажиллагаа зэрэг хүчин зүйлс нь тодорхой хэмжээнд сөргөөр нөлөөлж усны нөөц багасаж гол бохирдож байгаа мэдээ бий [Гадаргын усны тооллого 2005, Геоэкологийн хүрээлэнгийн бүтээл 2005-2013]. Туул гол нь Хан Хэнтийн нурууны Бага Хэнтий далайн түвшнээс дээш 2000 м өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдгийн өврийн салбар уулсаас эх авах Номин гол, Шороотын даваа /1918 м/-ны өвөр, Шар булгийн сарьдаг /2542 м/-ийн салбар уулсаас эх авах Шороотын давааны өврөөс гарах Нэргүй голын бэлчрээс Туул хэмээн нэрлэгдэнэ. [Даваа Г.2015]. Туул гол Орхон голд цутгах хүртлээ урт нь 871 км, 6-р эрэмбийн гол ажээ. Туул голд Хэнтийн нуруу, түүний салбар уулсаас эх авсан Галттай, Хийд, Хаг, Хонгор, Баруун, Зүүн Баян, Заан, Тэрэлж, Хөл, Улиастай, Сэлбэ Бөхөг, Түргэний зэрэг олон голууд цутгаж усан сүлжээг үүсгэнэ. Туул голын хөндий Улаанбаатар хотоос доош тавиурч урсацын алдагдал ихэснэ. Туул голын жилийн дундаж өнгөрөлт Улаанбаатар орчим 26.6, Сонгинод 25.8, Өндөр ширээтэд 24.1 шоо м/с байгаа нь дээрх дүгнэлтийг баталж байна. Голын ус хурах талбай 48868.4 ам.км байна.

2.5. Төсөл хэрэгжиж орчны амьтны аймаг, бүрэлдэхүүн

Уг агуулахын орчинд шувуудаас оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P.montanus*) бор шувуу, хөхөвтөр тагтаа (*C.Livia*), Сохор элээ (*Milvus migrans*), Шаазгай (*Pica pica*), Улаан хошуут (*Pyrrhcorax pyrrhcorax*), Хар хэрээ (*Corvus corone*), Хон хэрээ (*Corvus corax*) тохиолдоно. Хөхтнөөс гэрийн хулгана нутагшина. Шавьжийн ангиас Хатуу далавчтан буюу цохын баг (*Coleoptera*)- Жийгээ цохын овгийн (*Carabidae*)- *Tarhoxenus laticollis*, *Amara fodinoe*, *Harpalus amplicollis*, Арьс идэгч цохын овгийн (*Elateridae*)- *Selatosomus latis*, Мөлгөр цохын овгийн- (*Buprestidae*)- *Sphenoptera canaediculata*, Буглаа цохын овгийн- *Epicauta megacephala* *Epicauta sibirica*, Хайрсан далавчтаны багийн (*Lepidoptera*)- Дэнгийн эрвээхэйн овгийн (*Pyralidae*) *Prorophora albidogilvella*, Сарсан далавчтаны багийн Шоргоолжны овгийн (*Forimidae*) –*Tetramorium caespitum*, Сурфид, ялааны овгийн (*Syrphidae*)- *Paragus haemorrhous*, Махны ялааны овгийн (*Sarcophagidae*)- *Blaesoxiphella brevicornis*, *Servaisia subamericana*, *Servaisia panfilovi* элбэг тархалттай байна.

2.6. Төсөл хэрэгжих орчны нийгэм, эдийн засгийн хөгжил

Газар нутаг: Сонгинохайрхан дүүрэг 1992 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Сонгино нэртэй байгуулагдаж, улмаар 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 39 тоот "Дүүргийн нэрийг өөрчлөх тухай" тогтоолоор Сонгинохайрхан дүүрэг болгон өөрчилжээ. Тус дүүрэг нь 120,6 мянган га газар нутагтай, нийслэлийн баруун жигүүрт Баянгол, Хан-Уул дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Борнуур, Батсүмбэр зэрэг сумдтай хил залган оршино. Нийслэлийн хэмжээнд мал аж ахуй эрхлэх бүсийг тогтоохдоо Сонгинохайрхан дүүргийн 20, 21 дүгээр хороо буюу хориглох бүсийн хилийн зурвасыг Баруунтуруун, Тахилт, Шижир, Толгойт, Гүнт, Хужирт, Хадлан, Халзан, Мухартын даваа, Өвөрхангайн Хархорин, Сэлэнгийн Алтанбулаг чиглэлийн засмал замын уулзвараар тогтоосон байна. Эрчимжсэн мал аж ахуйг Жаргалант тосгонд хөгжүүлэх боломжтой бөгөөд энэ бүс нутаг нь хээрийн ерөнхий шинж төрхийг хадгалсан, чийглэг сэрүүн, ой нуга хээр хосолсон усан хангамж сайтай, бэлчээр элбэгтэй нутаг.

Газарзүй байршил: Нийслэл хотынхоо баруун өмнө талд сүндэрлэх тахилга сүлдэт уул нь хад асгатай хайлаас харгана ихтэй, агь, ганга, цагаан төмс, гандигарын мод зэрэг эмийн ургамал ургадаг, галт хар үнэгтэй учир өвөл цасгүй өвөлждөг гэсэн домог бий. Сонгинохайрхан уулын эзэн хөх үхэр унаж, араа соёо нь зөрсөн хөх өвгөн аугаа их эдийн засгийг баригч, хамгийг эрх мэдэлдээ хураагч, сайтар гялалзан харагдагч, үзэсгэлэнт Өндөрхайрханы өмнөх догшин хар үүлийн дунд сүрхий хилэнт бараан нүүртэй, гартаа улаан торгон молцогтой зэвсэг сэлэм, эрээн мод барьсан хөх өвгөний дүрийг дүүргийн сүлдэнд залжээ. Дүүргийн туг нь улаан хүрэн өнгөтэй торгон дээр сүлдийг өнгөөр ялгаж дүрслэдэг ба сүлд тэмдгийг туган дээр ямагт босоо байрлуулдаг уламжлалтай.

Хүн ам, айл, өрх: Тус дүүрэг нь хөдөөгөөс хот руу шилжин ирэгсдээр бүл нэмсээр өдгөө 65423 өрхийн 261917 иргэнтэй өнөр дүүрэг болжээ. Дүүргийн 32 хорооны нийт өрхийн 17721 нь буюу 27 хувь нь байшин хороололд амьдардаг.

Хөдөө аж ахуй: Мал тооллогын дүнгээр мал бүхий 20 хорооны 1379 өрхийн, 10 аж ахуйн нэгж байгууллагын нийт 62654 толгой мал тоологдсон байна.

ААН: Дүүргийн нутаг дэвсгэрт улсын хэмжээнд танигдсан олон үйлдвэр аж ахуйн нэгж бий. Тухайлбал, “Талх чихэр”, “Алтан тариа”, “Монсүү”, “Ган хийц”, “Шилэн хийц”, “Хүнс трейд”, “Мах импекс”, “Жем интернэшнл”, “Саван трейд”, “Ган хийц”, “Сүлжээ” ХК зэрэг томоохон аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр үйлдвэрүүд нийслэлийн нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 10 гаруй хувийг эзэлж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны бүрдэл хэсгүүдэд нөлөөлж болзошгүй байдлыг нөлөөллийн эрчмээр их, дунд, бага, нөлөөлөлгүй гэсэн үзүүлэлтээр нөлөөллийн үнэлгээг гаргав.

Хүснэгт 3. Төслийн үйл ажиллагааны үед үүсэх нөлөөллийн матрицын арга

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Нөлөөлөл гүй	Нөлөөллийн эрчим			Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх тайлбар
			Бага	Дунд	Их	
1.	Ургамалан нөмрөг түүний ургалт, хөгжилтөд үзүүлэх нөлөө		х	х		Төслийн барилга байгууламж нь Улаанбаатар хотын үйдвэр, үйлчилгээний суурьшлын бүс нутагт баригдсан тул бэлчээр, тариалангийн талбайд үзүүлэх сөрөг нөлөөлөл учруулахгүй.
2.	Хөрсөн бүрхэвч түүний бохирдол, эвдрэлд үзүүлэх нөлөө				х	Төслийн үйл ажиллагааны хүрээнд бодис тээвэрлэх зөөвөрлөх үед төслийн талбайн хөрсний өнгөн хэсгийн бүтцэд өөрчлөлт оруулж болзошгүй.
3.	Гадаргын болон газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлэх нөлөө		х			Төслийн хувьд ахуйн зориулалтаар худаг гаргасан бөгөөд энэ нь усны нөөцөд ямар нэг байдлаар нөлөөлөхгүй болно.
4.	Газрын гадаргын өөрчлөлтөд үзүүлэх нөлөө		х			Өөрийн төслийн талбайд 500м2 талбайд агуулахын зориулалттай барилга байгууламж баригдсан.
5.	Агаар орчны бохирдол эх үүсвэр бий болгох		х			Химийн бодисуудын хадгалалтын орчин нөхцөлийг тогтмол хянаж ажиллах нь агаар орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Гэсэн хэдий ч агуулахын агууржуулалтыг сайтар хангах хэрэгтэй.
6.	Амьтны амьдрах орчинд үзүүлэх нөлөө		х			Төслийн талбай нь суурьшлын бүс тул ойр орчимд хөхтөн амьтад амьдардаггүй нь төслөөс үзүүлэх нөлөөлөл байхгүй.
7.	Ажиллагсад болон төслийн талбайн ойр оршин суугчдын эрүүл мэндэд хохирол учруулах байдал			х		Санамсаргүй тохиолдлоор асгаралт тэдгээрийн ууршилтаас ажиллагсдын амьсгалын замд нөлөөлж болзошгүй. Иймд ажиллагсдын ажиллах нөхцлийг хангаж хүн нэг бүрийн, тусгай ажлын, химийн хорт бодисоос хамгаалах хэрэгсэл, амьсгалын замыг хамгаалах баг болон агууржуулалтыг сайтар хийж өгөх, аюулгүй ажиллагааны журам, стандартыг чанд сахих хяналттай байх шаардлагатай.
	Нийт нөлөөлөл		5	2	1	Төслийн хувьд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл бага юм. Гэсэн хэдий ч бодис тээвэрлэх, зөөвөрлөх, хадгалах үеийн хөдөлмөр аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах болон гэнэтийн осол эрсдлийн үед авах арга хэмжээг ажиллагсад тогтмол зааварчилгааг өгч байх.
	Эзлэх хувь, %		75%	15%	10%	

“

“Жи Эф Ай” ХХК

Нөлөөллийн эрчмээс харахад 2 буюу 15 % нь дунд, 2 буюу 75% нь бага, 1 буюу 10 % нь их нөлөөлөлтэй байна. Үүнээс харахад төлийн үйл ажиллагааны явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд “БАГА” буюу 75%-ийн нөлөөлөл үзүүлж болзошгүй байна. Харин бодисын тээвэрлэлт, зөөвөрлөлтийн үйл явц, ажилчдын болгоомжгүй байдлаас бодис асгарах, ууршиж болзошгүй нөхцөл байдлын хувьд ажиллагсад болон төсөл хэрэгжих орчинд ойр байх оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөлөөллийн хувьд “Дунд” буюу 15%-ийн магадлалтай байна. Иймд төслийн хүчин чадлаас хэтэрсэн үйл ажиллагаа явуулахгүй, ажиллагсдын хөдөлмөр, аюулгүй байдлыг сайтар хянах, заавар зөвлөмжийг цаг тухайд өгч үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дээрх болзошгүй сөрөг нөлөөлөл үүсэх эрсдэл бага юм.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Жи Эф Ай” ХХК-ний “Химийн бодис ашиглах, хадгалах, импортлох” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулсан болно.

Ерөнхий зүйл. Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн (цаашид төсөл хэрэгжүүлэгч гэх) байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газарт хүргүүлэн хянуулж, батлуулна. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)
- ✓ Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө. Тухайн жилийн БОМТ боловсруулах, биелэлтийг тайлагнах журамд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байх бөгөөд хийх ажлын зардлыг тус бүрчлэн тооцож төлөвлөнө. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан төлөвлөгөө
- ✓ Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө
- ✓ Төслийн талбай орчмын түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“

“Жи Эф Ай” ХХК

- ✓ Үйл ажиллагааны үеийн осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- ✓ Үйл ажиллагааны үеийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- ✓ Тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлт
- ✓ БОМТ-г нөлөөллийн бүсийн олон нийт, оршин суугчдад тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээний төлөвлөлт зэргээс бүрдэнэ.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар									
1.	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршимтгай, дэгдэмхий бодисууд агаарт уурших, исэлдэн урвалжих, салхиар тарах зэргээр чанар найрлагыг өөрчлөх	Химийн бодисын хадгалалтын хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны дараа уурших, задрах гэх мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савлагааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисыг агуулахад хадгалахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянаж, хуучин бодисыг эхэлж ашиглах зарчмыг баримтлах	Агуулах дотор	-	Дотоод зардал	-	-	Үйл ажиллагааны явцад байнга	MNS 6458:2014, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. MNS 5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. MNS 4990:2015 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
2.	Химийн хортой болон аюултай бодисын хог хаягдал болох сав баглаа боодлыг ил задгай хяналтгүйгээр хаясанаас халалт үүсэж, тэсэрч дэлбэрэх гэх мэт эрсдэл үүсэх	Химийн бодисын сав баглаа боодлын хаягдал болон ахуйн хог хаягдлын цэгийн битүүмжлэл, ариутгалд тогтмол хяналт тавих	Агуулах түүний орчин	-	130.0	-	130.0	Үйл ажиллагааны явцад байнга	MNS 4990:2015 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага

“Жи Эф Ай” ХХК

3.	Агааржуулалтын системийн ажиллагаа шаардлага хангаагүйгээс идэмхий бодисууд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.	Агуулахын агууржуулалтыг хянах, гарах агаарыг шүүлтүүрээр дамжуулах, тогтмол ажиллуулах	Агуулахын дотоод орчин	-	Дотоод зардлаар	-	-	Үйл ажиллагааны явцад байнга	Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2016 Хог хаягдлын тухай хууль /2017 он/
Хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар									
3.	Ахуйн болон хатуу хог хаягдлаар хөрс бохирдох	Бүх төрлийн хатуу болон ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал түр хадгалах саванд байнга хяналт тавих	Хог хаягдлын цэг, түүний орчинд	-	50.0	-	50.0	Үйл ажиллагааны явцад байнга	Хог хаягдлын тухай хууль /2017 он/, Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль MNS 5850:2019. “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
4.	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим, зөрчигдөж болгоомжгүй байдлаас химийн бодис алдагдсан тохиолдолд хөрс бохирдож болзошгүй	Химийн бодис урвалжийг алдагдахаас сэргийлж байнга анхаарал сэрэмжтэй ажиллах	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт	-	50.0	-	50.0	Үйл ажиллагааны явцад байнга	
Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар									
5.	Хур бороо, үерийн усаар төслийн талбай дахь ахуйн хог хаягдал, химийн бодисын агуулахаас гарах хаягдал угаагдан хөрсөнд нэвчиж улмаар газар доорхи усны чанар, найрлагад өөрчлөлт оруулж болзошгүй	Химийн бодисын сав баглаа боодлын хаягдалд байнгын хяналт тавьж, ил тархахаас сэргийлэх, тархаж бохирдуулсан тохиолдолд саармагжуулах бодис бэлдмэлийг байнга бэлэн байлгах	Бүх төрлийн хог хаягдлын цэг, химийн бодисын сав баглаа боодол	-	150.0	-	150.0		Усны тухай хууль, 22.1, 23.1, 24.1 зүйл заалт
6.	Гэнэтийн ослоос бодис газарт нэвчиж гүний усыг бохирдуулах улмаар хүний эрүүл мэндэд аюул учруулах	Агуулахын хашаанд байрлах гүний худгийн ойр орчинд хамгаалалтын бүс тогтоож, хашаажуулах	Гүний худаг, түүний орчин	-	100.0	-	100.0		
Нийт					-	-	480.0	-	-

4.2. Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тарих, мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нь үе шаттайгаар мод бут тарьж, ургуулж байгаа бөгөөд 2025 онд 50 ширхэг нарс мод тарьж ургуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 5.

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэр бум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэн мод, суулгац тарьж ургуулахаар төлөвлөсөн	50 ширхэг нарс тарьж ургуулна	Агуулахын хашаанд	1300.0	2025 он	MNS 5918:2008, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих арчлах
Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө			1300.0	-	-

4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртсөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлын тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг хийх шаардлагагүй болно.

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Тухайн төслийн үйлчилгээ болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд зайлшгүй нүүлгэх шаардлагатай иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй болно.

4.5.Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй болно.

4.6.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Авилаа осол эрсдлээс хамгаалах ажил нь химийн бодис зөөж, тээвэрлэх явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой юм. Доорхи хүснэгтэд төслийн үйл ажиллагааны явцад гарч болзошгүй осол, эрсдэл түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх ажлын хүрээ, давтамж, баримтлах стандарт зэргийг тусган оруулав. /Шаардагдах хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч нь санхүүгийн төлөвлөгөөндөө тусгасан байх шаардлагатай/.

Хүснэгт 5. Осол эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6.

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах стандарт, аргачлал
Аянга буух, цахилгаан хэрэгслийн гэмтэл, хэт халалт зэргээс үүдэн гал түймэр гарах	Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойг зохих газруудад байрлуулах, аюулын гарцын байрлалыг заасан самбар хадах, галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавьсан байх	Химийн бодисын агуулахад	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн үйл ажиллагааны явцад байнга хяналт тавих	Гамшгаас хамгаалах тухай: Зүйл 27-1
	Аянга газардуулагчийг ойролцоох өндөрлөг газруудад суурилуулж өгөх, цахилгаан дамжуулах, цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх	Төслийн талбайд	-	2025 он	Галын аюулгүй байдлын тухай: Зүйл 16-1, 2; Зүйл 18-1, 2;
Үер	Ус зайлуулах шуудуу, даланг шаардлагатай газарт хийх	Үерийн ус орж ирэх магадлалтай газруудад	Дотоод төлөвлөлтөөр	Үйл ажиллагааны туршид	Гамшгаас хамгаалах тухай хууль
Химийн бодис алдагдсанаас ажиллагсадын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Ажиллагсад эрүүл мэндийн үзлэгт орсон байх	Ажиллагсад	200.0	Жилд 1 удаа	MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
	Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангасан байх	Химийн бодисын агуулахад	150.0	-	
	Химийн бодистой харьцах үеийн зориулалтын хувцастай байх /гутал, резинэн бээлий, хамгаалалтын хошуувч/		85.0	-	
Химийн бодис болон химийн бодис агуулсан хольц асгарах	Сургалт, туршилт ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах	Ажиллагсад	Дотоод төлөвлөлтөөр	Үйл ажиллагааны туршид	
Нийт дүн			435.0	-	-

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний арга хэмжээний зардал

Төслийн үйл ажиллагааны үед ажилчдын ахуйн хог хаягдал, химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал гарна. Төслийн үйл ажиллагааны үед гарсан хог хаягдлыг байгаль орчинд бохирдол багатайгаар зайлуулах, ангилан ялгах дахин ашиглах асуудлыг зохицуулахад менежментийн төлөвлөгөөний зорилго оршино. Ахуйн лонх, лааз, цаас, хоолны үлдэгдэл, бусад гэсэн байдлаар нь ангилан хадгалж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг хогийн цэгт зайлуулах нь зүйтэй. Аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгч мэргэжлийн түвшинд устгуулах шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэгч нь БОАЖСайлын А/21 тушаалын Хавсралт 3. Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлангийн маягт, Хавсралт 5. Аюултай хог хаягдал цуглуулах үйл ажиллагаа эрхлэгчийн тайлангийн маягтын дагуу тус тус бүртгэлийг хөтөлж ажиллана.

Хүснэгт 7.

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлын цэг, хог хаягдал ангилан ялгах талбай, төслийн орчинд бохирдол үүсгэж болзошгүй	Хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Сард 2 удаа	150.0	Хог хаягдлын тухай хууль
	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Тухай бүрт нь	-	
	Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулж байх	Тогтмол	Гэрээгээр	MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
	Химийн хог хаягдал, химийн бодисын сав, баглаа боодлыг аюултай хог хаягдлыг тухай бүрт нь аюултай хог хаягдал зайлуулах гэрээний дагуу хүлээлгэн өгөх	Тухай бүрт нь	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр	ЗГ-н 2018 оны 116 тоот Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, бүртгэх тайлагнах журам
Нийт зардал /мян.төг/			150.0	-

4.8. БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь нутаг дэвсгэрийн дүүрэг, хороо иргэдийн нийтийн хуралд БОМТ -ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

4.10. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүснэгт 8.

№	Хийгдэх ажлын нэр төрөл	Хийгдэх шаардлага	Хийх хугацаа	Ажлын хэмжээ	Шаардагдах хөрөнгө
1.	Байгаль орчныг хамгаалах асуудлаар жил бүрийн тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цаг тухайд нь гаргаж өгөх	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу	Жил бүр	Жил бүр БОМТ төлөвлөгөөг боловсруулж батлуулах	-
2.	Хог хаягдлын талаар боловсрол олгох сургалтыг мэргэжлийн хүмүүсээр зохион байгуулах	Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгуулагаас сургалт авах	2025 он	Жил бүр	Дотоод зардлаар
3.	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлж байх	-	Үйл ажиллагааны явцад тогтоосон хугацаанд		Гэрээний дагуу

4.11. Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

“Жи Эф Ай” ХХК-ийн “Химийн бодис импортлох, хадгалах, худалдаалах” төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, байгаль орчны доройтол, гэнэтийн бохирдлыг хянах, бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор байгаль орчны мониторингийн үйл ажиллагааг явуулна. Мониторинг нь байнгын ажиглалт шинжилгээгээр гарсан үзүүлэлтүүдийн хяналт тэдгээрийн үнэлгээ болон хэтийн төлөв байдлыг урьдчилан таамаглах зэрэг үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааг хяналт, төлөвлөгөөтэй, цэгц явуулахын тулд “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” (ОХШХ)-ийг боловсруулан мөрдөнө.

Орчны бохирдлын байдлын ажиглалт, хяналтыг орчны дээжид хийсэн тоон болон чанарын шинжилгээний үр дүнд үндэслэн явуулна. Шинжилгээгээр гарсан үр дүнг стандартын дагуу батлагдсан ЗДА-тай харьцуулан орчны бохирдлын бие даасан үнэлгээ хийх бөгөөд уг ажлыг хөнгөвчлөхийн тулд тусгай эрх бүхий төрийн байгууллагуудаар батлагдсан ББ-уудын нормативуудыг энэхүү тайланд оруулав.

Байгаль орчны хяналт шинжилгээнд ашиглагдах норматив үзүүлэлтүүд

Хүснэгт 9. Агаар дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж /ЗДА/

№	Бохирдуулагч бодис	Хортой нөлөө үзүүлэх хэмжээ мг/м3	Ажлын бүсийн ЗДА мг/м3	Хүн ам орших бүсийн ЗДА мг/м3	Үнэр	Аюулын зэрэг
1.	Азотын давхар исэл	0,09	0,085	0,04	Хурц	2
2.	Нүүрстөрөгчийн давхар исэл	5	-	3	-	3
3.	Тоос	0,5	-	0,2	-	3

Хүснэгт 10. Хөрсөнд байж болох хорт бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж /ЗДА/

№	Бохирдуулагч бодис	Зөвшөөрөгдөх дээд агууламж, мг/кг
1.	Нефть, нефтийн бүтээгдэхүүн	0
2.	4 этилт хар тугалга	0
3.	Хар тугалга	0,8
4.	Бензол	0,3
5.	Бензин	0,1
7.	Pb+2	6,0
8.	Hg+2	2,1
9.	Cu+2	3,0
10.	Пирит	0,0

Хүснэгт 11. Гадаргын усанд байж болох бохирдуулагч болон хорт бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж /ЗДА/

№	Найрлага	ЗДА, мг/л	Хөнөөлийн хязгаарлагч үзүүлэлтүүд (ХХҮ)
1.	Жинлэх бодис	Тавих усан дахь фоны хэмжээ + 0,25 мг/л	
2.	Ууссан хүчилтөрөгч	6	
3.	Хлоридууд	300	Эрүүл ахуй - токсикологийн
4.	Сульфатууд	100	Эрүүл ахуй - токсикологийн
5.	ХХХ	15	
6.	БХХ5	2 (БХХбүрэн.)	
7.	Аммоны азот	0,39	Токсикологийн
8.	Нитритын азот	0,02	Токсикологийн
9.	Нитратын азот	9,1	Эрүүл ахуй - токсикологийн
10.	Фосфатууд	0,61	Ерөнхий эрүүл ахуйн

11.	Ерөнхий төмөр	0,1	Токсикологийн
12.	Зэс	0,001	Токсикологийн
13.	Хром (III)		Токсикологийн
14.	Фенолууд	0,001	Загасны аж ахуйн
15.	Нефтьбүтээгдэхүүн	0,05	Загасны аж ахуйн
16.	Анион идэвхит НГИБ (нийлэг-жүүлсэн гадаргуу идэвхит бодис)	0,1	Токсикологийн

Хүснэгт 12. Ундны усанд байж болох бохирдуулагч болон хорт бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж /ЗДА/

№	Найрлага		Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх агууламж
1.	Орга-но-леп-тик	Өнгө	-	Өнгөгүй
2.		Үнэр	-	Үнэргүй
3.		Амт	-	Амтгүй
4.	Эрдэсжилт		г/л	1,0
5.	Хатуулаг		мг*экв/л	7,0
6.	Төмөр		мг/л	0,3
7.	рН		-	6,5-9,5
8.	Нитрат		мг/л	50,0
9.	Мик-ро-биологи	Колииндекс		Байхгүй
10.		Микробын ерөнхий тоо (МЕТ)	ш	50,0

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 13.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	2025 оны зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Агаар							
1	Агаар дахь тоосжилт, нийт тоос, PM_{10} Агаар дахь хорт хийн агууламж $CO, CO_2, SO_2, NO_2, O_2, CH_4, NH_3, Pb$	Агуулахын хашаан дотор Агуулах дотор	Жилд 2 удаа	Агаарын ерөнхий чанарын үзүүлэлт	75,0	150.0	МУ-н стандартууд, MNS (ISO) 4585:2016 “Агаарын чанар”, MNS 4585:1998 “Агаар орчны чанарын үзүүлэлт”; MNS 0017-2-3-16:1988 “Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам” Дээжлэхдээ MNS 4585-98; MNS 4048:1988 баримтлах Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885 : 2008
Хөрс							
	Ялзмаг Урвалын орчин-рН Карбонат Хөдөлгөөнт фосфор, кали (P_2O_5, K_2O) Цахилгаан дамжуулах чанар	Агуулахын хашаан дотор	Жилд 2 удаа	Агрохимийн үзүүлэлт, хүнд металл	25.0 40.0	100.0 160.0	MNS 5850 : 2019, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
	Хүнд металлууд Pb, Co, Ni, Cr, Cd						
Ус							
3.	pH, Нийт хатуулаг ($CaCO_3$), Ca, Mg, Na, K, Fe, NH_4 , SO_4 , NO_2, NO_3, CO_3, HCO_3 , Ni-ийн агууламж, амт, үнэр, өнгө, тунгалаг, тунадас	Агуулахын хашаанд байрлах гүний худаг	Жилд 1 удаа	Хими шинжилгээ	60.0	60.0	MNS ISO 5665-5:2001 “Усны чанар. Ундны уснаас дээж авах стандарт. “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018”
Нийт						470.0	-

2025 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт зардал: 2835.0 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

25

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл			
Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Дамба овогтой Бат-Отгон-г Захирал-р томилсныг бүртгэв.	2009.11.11	Э.Дамдинсүрэн
2	Дахин гэрчилгээ олгов.	2018.09.04	Ж.Нямдорж



